



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2021 оны 10 сарын 07 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 17 дугаар хуралдааны тэмдэглэлд:

ХҮИ.1 ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Таван толгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн талаар авах арга хэмжээний тухай танилцуулга.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 47 дугаар тэмдэглэлээр “Таван толгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг тодорхой болгох ажлыг шуурхай зохион байгуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл) нарт даалгасны дагуу “Таван толгой түлш” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн нийт хувьцааны 51 хувийг “Эрдэнэс-Таван толгой” хувьцаат компанид, төрийн эзэмшлийн 49 хувьд ногдох төлөөллийг хэрэгжүүлэхдээ 39 хувийг Эрчим хүчний яам, 10 хувийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар тус тус эзэмших нь зүйтэй гэж үзээд Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэхээр тогтов.



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

132002016